



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/89

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", "ж", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Төрийн болон болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 47 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/58 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2021 оны 06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс эхлүүлж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар (А.Мөнхтуяа), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

2. Улсын Онцгой комиссын шийдвэрээр хот хоорондын зорчигч тээврийн хөдөлгөөн нээсэнтэй холбогдуулан нөөц бүрдүүлэх зорилгоор 1000 ширхэг түргэвчилсэн оношлуурыг худалдан авах зардлыг гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын зардлаас шууд гэрээ байгуулан санхүүжүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

3. Авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тухай бүр нь танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



481210243